

**ПРОФЕССОР Э.РАВДАНГИЙН МОНГОЛ ГАЗАР НУТГИЙН
НЭРИЙН ТАЛААР ТУУРВИСАН БҮТЭЭЛҮҮДИЙН ТУХАЙ**

Ж.Сэржээ¹

Академич А.Лувсандэндэв 1980 онд “Монгол орны газар зүйн нэр судлал нь эдүгээ хүртэл системтэй шинжлэх ухаан болж чадаагүй байна. Монголын газар усны нэрийн судлалыг системтэй шинжлэх ухаан болгохын тулд асар их бэлтгэл ажил хийх хэрэгтэй юм. Үүнд юуны өмнө монгол орны газар усны нэрийн сан байгуулах нүсэр их хөдөлмөр хүч, цаг шаардагдах ажлыг тойрч гарах аргагүй, заавал гүйцэтгэх хэрэгтэй нь хэн бүхэнд мэдээжийн хэрэг билээ. Газар усны нэрийн картын сан байгуулахын тулд монгол орны газар усны макро, мезо, микро нэрийг аль болохуйц бүрэн цуглуулсан байх хэрэгтэй юм.” /1:157/ гэж бичиж байлаа.

Энэ цагаас хойш төдийлөн их цаг хугацаа өнгөрөөгүй ч өнөөдөр монголын газар нутгийн нэрийн судалгаа эрийн цээнд хүрч, системтэй шинжлэх ухаан болон төлөвшиж байна. Ингэж хэлэхийн учир нь гэвэл, академич А.Лувсандэндэвийн онцлон тэмдэглэсэнчлэн, **юуны өмнө монгол орны газар усны нэрийн сан байгуулах нүсэр их хөдөлмөр хүч, цаг шаардагдах ажлыг тойрч гарах аргагүй, заавал гүйцэтгэх хэрэгтэй нь хэн бүхэнд мэдээжийн хэрэг билээ.** Энэхүү асар их хүч хөдөлмөр, цаг хугацаа, зохион байгуулалт шаардсан ажлыг нэгэнт хийчихээд байна. Энэ бол Э.Равдангийн шууд удирдлага, санаачлагаар зохиосон “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь” нэрийн дор хэвлэгдэн гарсан цуваа гурван том толь /бүгд 11 боть/ юм. Үүнд:

1. Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (Манж, Богд хаант монгол улсын үе) УБ. 2004 он. нэгэн боть, 377 тал. бүтээлд Манжийн дарангуйллын үе болон Богд хаант монгол улсын үеийн 4 аймгийн 81 хошуу, 10 шавь, 24 өртөө харуулын давхардаагүй тоогоор нийт 107 газрын зургаас авсан 12000 орчим нэр оржээ. Монгол улсын Үндэсний төв архив, Монгол улсын үндэсний номын санд хадгалагдаж байгаа эдгээр газрын зургуудын хамгийн эртнийх нь Манжийн Төр гэрэлтийн 23 дугаар он буюу 1843 оны Сэцэн хан аймгийн Бишрэлт ван Миюүрдоржийн хошууны нутгийн зураг юм байна. Нэг хошууны газрын зураг 2-5 удаа хийгдсэн байдгийг тооцон үзвэл дээрх 107 зургийг наад зах нь хоёр, гурван зуун зургаас сонгон авсан нь тодорхой бөгөөд энэ үеийн газрын зургууд цаас, даавуун дээр монгол бичгээр, гар бичмэл хэлбэртэй байдгийг бодолцвол хичнээн хүч хөдөлмөр орсон нь тодорхой болно. Толийн эцэст уг тольд оруулсан аймаг хошуудын газрын зургуудаа: аймаг, хошуу, шавь, өртөө, харуулын нэр; газрын зургийн нэр, үйлдсэн он, одоогийн аль аймаг сум болохыг нь

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

харьцуулан заасан хавсралт хийж өгсөн нь тольд орсон нэрсийн эх үүсвэрийн баталгаа болсон байна.

2. Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (XX зууны 30-40-өөд оны үе). УБ. 2006. хоёр боть. 750 тал. бүтээл бол 2004 онд хэвлүүлсэн толийн дараагийн үеийг хамарсан түүний зүй ёсны үргэлжлэл болж байгаа юм. Энэ толийн эх сурвалж нь 1930-аад оны сүүлээс тэр үеийн ЗХУ-ын хүч хөрөнгөөр БНМАУ-ын нийт нутаг дэвсгэрт нарийвчилсан хэмжилт хийсний үр дүнд бүтээсэн 1:200000 масштабтай, 1942-1956 оны хооронд тэр үеийн ЗХУ-д хэвлэгдсэн нийт 316 газрын зураг бөгөөд тэдгээрт тэмдэглэгдсэн 37000 орчим газар нутгийн нэрийг энэ хоёр боть тольдоо багтаажээ. “Энэхүү толийн эх сурвалж болсон газрын зургууд нь топограф буюу газрын хэмжих зүйн үүднээс үзвэл шинжлэх ухааны үндэслэлтэй зохиогдсон, түүнээс хойш хэвлэгдсэн монголын газар нутгийн олон төрлийн толийн / газрын зургийн Ж.С./ суурь дэвсгэр болсон үнэт бүтээл юм. Харин харь хүмүүсийн тэмдэглэсэн монгол газар нутгийн нэр нь олон талаар алдаа мадагтай байна. ...Тэрхүү олон нэрийг газар дээр нь тодотгон залруулах буянтай агаад чимхлүүр ажлыг ШУА-ийн Газар зүйн хүрээлэнгийн ажилтнууд шинжлэх ухааны доктор Дамбын Базаргүрийн удирдлагаар хийж гүйцэлдүүлсэн нь эл толь нийтийн хүртээл болох нэг талын чухал нөхцөлийг хангасныг тэмдэглэх нь зүйн хэрэг болно” гэж Э.Равдан толийнхоо өмнөтгөлд бичсэн байна. Энэ тольд Монголын газар нутгийн нэр 1930-аад оны засаг захиргааны хуваарийн дагуу тэмдэглэгдсэн ба ашигласан 316 зургийн жагсаалтыг зургийн нэр, индекс, зурагт хамааран тэмдэглэгдсэн аймаг сумдыг хавсралт болгон хэвлүүлжээ.

3. Дээрх хоёр толийн үргэлжлэл болох “Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь” (XX зууны 70-80 оны үе), 5 боть, 8 дэвтэр, нэрийн хайлтын CD – тэй толийг 2004 онд хэвлүүлэн гаргасан юм. Энэ асар том толь бичигт Монгол Улсын Их Хурлаар батлагдсан нийт 214805 нэр оржээ. Энэ толийн гол зорилго нь монгол газар нутгийн аль болох олон нэрийг зүйлээр хуваан, бичлэгийг нь монгол улсад одоо мөрдөж байгаа кирил үсгийн дүрмийн дагуу нэг мөр болгох, тэрхүү тэмдэглээг ром үсэгт шилжүүлэх хувилбарыг боловсруулан баталгаажуулж, уг нэр бүхий нутаг газрыг засаг захиргааны хуваарийн дагуу байрлалыг нь тодорхойлоход чиглэжээ. Зохиогчид дээрх нэрсийг хэл шинжлэл, толь зүйн үүднээс боловсруулж, тэдгээрийг 415 дэвсгэр нэрээр зүйл хуваан байрлуулжээ. “Зүйлчилсэн толь” нь ном, цахим диск (CD) гэсэн хоёр хэлбэртэй бөгөөд цахим диск нь хайлтын тогтолцоотой тул хэрэглэгч олох гэсэн нэрээ кирил, ром үсгийн алианаар ч олж ашиглах боломжтой болсон юм.

Ийнхүү эл цуврал гурван тольд давхардсан тоогоор монгол газар нутгийн 270000 орчим нэр оржээ. Өөрөөр хэлбэл ХҮШ зууны хоёрдугаар хагасаас эхлээд эдүгээг хүртэл бүтээсэн монголын нийт 600 орчим газрын зурагт тэмдэглэгдсэн нэр орсон нь монголын газар нутгийн нэрийг түүх, газар зүй, нүүдэлчдийн зан үйл, хэл шинжлэл, домог зүй зэрэг олон шинжлэх ухааны үүднээс судлахад маш чухал, бэлэн, судалгааны найдвартай материалыг буй болгосон хэрэг юм. Энэхүү зүйлчилсэн толь бичгийнхээ тухай Э.Равдан “Дээрх бидний тольд газар нутгийн нэрийг дэвсгэр нэрээр нь зүйл хуваан байрлуулсан болно. Толийг, бүрдүүлсэн нэртэй нь дүйлгэн үзвэл толь нь олон нэрийн “орон гэр”, ур шаардсан “уран барилга” гэлтэй. Тийнхүү үзвэл газар нутгийн маань нэр зүйл хуваасан тольд журамлагдсанаар цогцолбор биет шинжийг оллоо хэмээн зориглон дүгнэе. Толь нь уран барилга шиг мөн чимхлүүр, бүрэлдүүлэгч “тоосго” бүрээ олон талаас нь сонжсон “бүтээн байгуулалтын нэгэн талбар” мөн. Харин

эл хүчир ажлыг орчин үед цахимын программаар үйлдэх боломжтой болсон нь бидний ажлыг ихээхэн хөнгөвчиллөө.” /2: ҮГ тал/ гэсэнтэй санал нэг байна.

Эдгээр толь бичгээс өмнө газар зүйч эрдэмтэн Ш.Шагдар “Монголын газар зүйн нэрийн товч толь бичиг” зохиож, гурван удаа нэмэн засварлаж хэвлүүлээд байгаа нь дээрх толь бичгүүдийг хэвлэгдэн гарах хүртэл монголын газар нутгийн нэрийн судалгааны гол хэрэглэгдэхүүн, болж байлаа. Гурав дахь хэвлэлдээ Ш. Шагдар 8000 орчим газар нутгийн нэрийг оруулсан бөгөөд түүний дотор 4200 гаруй уул, нуруу, тал, хөндийн нэр, 520 гаруй гол мөрөн, 230-аад нуур цөөрөм, 90 орчим даваа, хөтөл, 240 гаруй рашаан ус, 290 орчим элс, говь, 40 орчим булаг, байн бүрд, 380 гаруй аймгийн төв, сум, суурин, 200 орчим түүх соёлын дурсгал, 160 орчим ашигт малтмалын орд, 800 гаруй тахилгатай уул, ус, 50 орчим улсын тусгай хамгаалалттай газар, 20 гаруй хилийн боомтын нэрийг үсгийн дарааллаар нэгтгэн оруулсан байдаг. / 3: 3/ Бас нэр бүрийн байршил, зарим тохиолдолд уртраг, өргөрөг уулын өндрийн хэмжээ зэргийг заасан тайлбар өгүүлэлтэй, нэвтэрхий толийн шинжтэй бүтээл юм.

Э.Равдангийн хариуцан эрхэлж хэвлүүлсэн зүйлчилсэн толь бол хамарсан цаг хугацаа, эх сурвалж, нэрийн тоо хэмжээний хувьд өнөөгийн монгол улсад хэвлэгдсэн бүх төрлийн толь бичгүүдээс илт давуу, даацтай бүтээл болсныг хүлээн зөвшөөрөх ёстой.

Монгол газар нутгийн нэрийн судалгааг дэлхийн хэмжээний шинжлэх ухааны салбар болгон хөгжүүлэхэд гадаадын олон эрдэмтэн ихээхэн хүчин зүтгэл гаргаж, олон арван бүтээл туурвин олон улсын нэр хүндтэй эрдэм шинжилгээний хэвлэлүүдэд хэвлүүлэн эрдэмтэн судлаачдын хүртээл болгосон юм. Чингис хааны байгуулсан Монголын их эзэнт улсын хувь төөргийг даган монгол газар нутгийн нэр дэлхийд цацагдаж олон орны хэл соёлд шингэн идээшсэн байдаг. Тэр бүгдийг шүр сувд түүх лугаа адил судлахын үлгэрийг гадаадын олон эрдэмтэн үзүүлсэн ба тэдгээр эрдэмтдийн бүтээлүүдээс “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр” нэртэй хоёр боть бүтээлийг профессор Э.Равдангийн санаачлага, удирдлагаар орчуулан хэвлүүлээд байна. 2005 онд хэвлэгдэн гарсан нэгдүгээр ботид нь Афганистан, Иран, ОХУ, Казахстан, Киргизстан, Узбекистан, Ордос, Баруун зүүн Сибир зэрэг нутагт тархсан монгол нэрийн судалгааны 20 гаруй өгүүллийг орос, англи, герман, франц хэлээс монголчлон оруулсан бол, 2006 онд хэвлэгдсэн хоёрдугаар ботид нь гол төлөв өнөөгийн БНХАУ-ын нутагт байгаа газар нутгийн монгол нэрийг эртний хятад, араб, перс, монгол зэрэг хэлээр бидний үед уламжлан ирсэн эх сурвалж бичгүүдийг шүүн судалсан П.Пеллио, Н. Поппе, П.Буудберг, Өвөр монголын өөртөө засах орны судлаачдын бичсэн судалгааны нийт 30 гаруй өгүүллийг эрдэм шинжилгээний бичгүүд болон судалгааны номуудаас түүн шигшиж, монгол хэлнээ орчуулсан байна. Түүнчлэн энэ II ботид Их эзэн Чингис хааны нэр өнөөгийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны газар нутгийн нэрэнд мөнхөрсөн тухай өгүүлсэн 120 домгийг цөөнгүй ном, товхимолуудаас түүвэрлэн оруулжээ. Энэхүү хоёр боть бүтээлд багтсан судалгааны зохиолуудыг хэн бүхэн олж, судалгаандаа ашиглахад бэрхшээлтэй байсан бол одоо бэлэн судалгааны материалтай боллоо. Нөгөө талаар эдгээр өгүүлэл, судалгааны зохиолуудыг МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн тухайн хэлээр мэргэшсэн мэргэжлийн багш нар орчуулсан тул орчуулгын чанарын хувьд эргэлзэх зүйлгүй болсон билээ.

Эцэг өвгөд маань эх хэлнийхээ үгээр яруу сайхан урлан бүтээж, хойчийн олон үеийнхэндээ үлдээсэн эрхэм нандин өв болох монгол газар нутгийнхаа нэрийг ийнхүү үе үеэр нь ботилон үлдээж, бас дээр нь гадаадын алдартай монгол судлаач эрдэмтдийн

судалгааг нэгтгэн өнөө, ирээдүйн судлаачдын гар дээр тавьсан нь нэгэн хүний, нэгэн насанд хийж болох хангалттай бүтээл юм. Ингэж хэлж байгаа нь МУИС-ийн ГХСС-ийн дэргэд ажиллаж буй Нэр зүйн судалгааны төвийн ажлыг бүхэлд нь ганц хүний бүтээл гэж хэлэх гэсэн санаа биш бөгөөд гар, сэтгэл нийлсэн судалгааны хамтлагийн гишүүн бүрийн хүчин чармайлт туйлын чухал гэдэг нь тодорхой юм. Гэвч ийм том хэмжээний, нөр их ажлыг санаачлан, ачааны хүндийг нуруундаа үүрч өөрөө хийхийн зэрэгцээ судалгааны ажлын чиглүүлэгч, удирдагч байх нь хэрийн хүний хийж чадах ажил биш гэдгийг тодруулан хэлэх гэсэн хэрэг билээ.

Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор, профессор Э. Равдан өөрийн буй болгон бүтээсэн эрдэм шинжилгээний арвин их бааз суурь дээрээ үндэслэн монгол газар нутгийн нэрийн судалгааны нэгэн сэдэвт зохиол хоёрыг бичиж хэвлүүлээд байна. Тэр бээр “Монголын газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа” /УБ.2004. 322 тал/, “Монгол орны газар нутгийн нэрзүй” /УБ.2008, 532 тал./ хэмээх судалгааны хоёр том бүтээлийг туурвисан нь “Монгол нэр зүй” хэмээх шинжлэх ухааны шинэхэн салбарт, ялангуяа судалгааны хэдхэн өгүүллийн хэмжээнд байсан монгол газар нутгийн нэрийн судалгааны хөгжилд оруулсан түүний жинтэй хувь нэмэр, гавьяа хэмээн үнэлж болно. Өөрөөр хэлбэл монгол газар нутгийн нэрийн талаар түүний хийсэн судалгааны ажлууд нь монгол хэлний газар нутгийн нэрийн судалгааг олон улсын хэмжээнд хүртэл урагшлуулсан гэхэд хэтрүүлэг болохгүй гэж санаж байна. Энэ хоёр бүтээлийн тухай товчхон өгүүлбэл:

Э.Равдан “Монголын газар нутгийн нэрийн хэлбэр-утгазүйн судалгаа” /УБ.2004/ бүтээлийнхээ тэргүүн хэсэгт, газар нутгийн нэрийн онолын суурь асуудлаар Оросын болон Өрнөдийн олон орны нэртэй эрдэмтдийн үзэл баримтлалыг задлан шинжилж, өөрийн байр суурийг илэрхийлсэн байна. Мөн монгол газар нутгийн зураг зүй, нэр судлалаар гарсан эрт эдүгээгийн олон бүтээлийг нийтэд нь агуулгын хувьд: 1. Газрын зурагт монголчууд нутаг усаа тэмдэглэж байсан уламжлал, 2. Газар нутгийн нэрийн гарвал зүйн буюу цуваа цагийн судалгааны тойм, 3. Газар нутгийн нэрийн хам цагийн судалгааны тойм, 4. Монголын төр, засгаас газар нутгийн нэрийн талаар авсан арга хэмжээ гэж дөрөв хуваан тоймлосон байна. Тухайлбал монголчууд газар усаа газрын зурагт тэмдэглэж байсан уламжлал манай эриний 46 оноос үүдэлтэй, 1267 онд Хубилай хаан дэлхийн бөмбөрцөг, од эрхэсийг хэмжих 6 төрлийн багажтай байсан, тэрхүү бөмбөрцөгт дэлхийн эх газар, усны харьцааг зөв тодорхойлсон, монгол газрын зургийн өвөрмөц онцлог зэргийн талаар гадаад дотоодын олон эрдэмтдийн судалгааг түшиглэн дэлгэрэнгүй өгүүлсэн байна. /зохиолын 19-30-р тал/

“Монгол газар нутгийн үгийн сангийн бүрэлдэхүүн” дэд хэсэгтээ зохиогч зүйл хуваасан толийнхоо агуулга 214805 оноосон нэрийн үгийн санг бүрдүүлсэн 540140 үгийг судалгаандаа хамруулж, үгийн сангийн бүтцийг давтамжаар нь тодотгохдоо үг, түүний хувилсан хэлбэрийг бие даасан нэгж болгон үзэж нийт 20336 үгийг тусгайлан судалжээ. Зохиогч энэ хэсэгтээ монгол газар нутгийн нэрийг утга зүйн талаар нарийвчлан судалж, утга зүйн дэлгэрэнгүй ангиллыг хийсэн байна. Түүний хийсэн ангилал нь урьд өмнө хийж байсан Ч.Догсүрэн, А.Лувсандэндэв, О.Сүхбаатар нарын ангиллаас илүү нарийн, монголын газар нутгийн нэрийн олон талт онцлогийг бүрэн харуулж чадсан гэж үзэж байна. Э.Равдангийн утга зүйн судалгааны давуу тал нь юунд байна вэ? гэвэл, тэр өөрөө монголын газар нутгийн нэрийн бараг бүрэн цуглуулгыг бий болгон 11 боть толь болгон хэвлүүлсэн судалгааны бааз дээрээ тулгуурлан задлан шинжилжээ, нэгтгэн дүгнэлт хийснээрээ өмнөх судлаачдаас хавьгүй давуу талыг буй

болгож чадсанд оршино. Би энд монголын газар нутгийн нэрийн бараг бүрэн цуглуулга гэж хэлснийг, зохиогч өөрөө “Бидний хэлхээ гурван тольд газрын зурагт тэмдэглэгдсэн, тэмдэглэгдээгүй 270 000 орчим нэр оржээ. Энэ хэдийвээр нэр давхардсан ч гэсэн бага тоо биш ч бидний багцаалж байгаагаар монгол газар нутгийн маань нэрийн гуравны нэг нь болох болов уу” хэмээн /4:Ү тал/ бичсэнтэй харьцуулахад миний дээрх үг хэт дөвийлгөсөн шинжтэй харагдаж магадгүй. Үүний учир нь, нэгдүгээрт Э.Равдан зүйлчилсэн толийнхоо 11 ботид одоо байгаа монгол улсын газрын зургууд, тэнд тэмдэглэгдсэн газрын нэрсийг бүрэн оруулсан, өөрөөр хэлбэл энэ тольд монгол улсын газар нутгийн макро, мезо төвшний нэрс үндсэндээ орсон гэсэн үг юм. Хоёрдугаарт, газрын зурагт тэмдэглэгдэж байгаагүй нэрс одоо үлдсэн гэсэн үг юм. Газрын зурагт тэмдэглэгдэж байгаагүй нэрс гэдэг маань тухайн нутагт оршин сууж буй цөөн хүнээс өөр хүн бараг мэдэхгүй, микро төвшний нэрс юм. Эдгээр нэр тооны хувьд олон нь ч үнэн. Гэвч тэдгээрийг бүрэн хамруулан судалгааны эргэлтэд оруулна гэдэг маш хэцүү. Жишээ нь, нэг сумын дотор байгаа атлаа өөр багийн хүн нарийвчилсан нэрийг нь мэдэхгүй газар монгол зөндөө бий. Энэ бүгдийг нэгтгэн, судалгааны нэгэн бааз суурь бий болгох нь ихээхэн цаг хугацаа, хөрөнгө, хүч шаардсан нүсэр ажил болох нь тодорхой. Ийм учраас би өнөөдрийн хэмжээнд нэгтгэж, толь болгон хэвлүүлэх хэмжээнд олдож болох газрын нэрийг бараг бүрэн цуглуулсан гэсэн утгаар хэлсэн билээ.

Э.Равдан “Монгол орны газар нутгийн нэрзүй”(нэрийн бүрэлдэхүүн, байршил, хувьсал) ганц сэдэвт зохиолоо 2008 онд хэвлүүлэн гаргалаа. Энэ зохиол үндсэн хоёр хэсэгтэй юм. Эхний хэсэгт нь нэрийтгэл ба оноосон нэр, оноосон нэр ба дэвсгэр нэрийн утга-хэлбэрийн харьцаа, тэдгээрийн зарчмын ялгаатай талууд, аливаа оноосон нэрийн бүтэц зэрэг онолын цогц асуудлаар зохиогч өөрийн үзэл баримтлалаа илэрхийлжээ. Түүний шинэлэг тал нь оноосон нэрийг тодорхой хэлний үгийн сангийн хүрээнд биш, хэлний тогтолцооны харьцангуй бие даасан дэд тогтолцоо болгон судлах үндэслэлийг дэвшүүлэн тавьж нотолсонд оршино. Зохиогч “Оноосон нэр нь нэгэн цагийн нэрийтгэл нэр мөн” гээд цааш нь “Аливаа оноосон нэр нь үг биш” гэжээ. /6:9/ Энэ нь уламжлалт хэл шинжлэлд “оноосон нэр үгээр бүтдэг, тухайн хэлний үгийн сангийн нэг хэсэг” хэмээн үзэж ирсэн хүмүүст хачирхалтай байж болох ч, оноосон нэрийн мөн чанарыг нарийн таньж мэдвэл, түүний үг үнэн болохыг зөвшөөрөх болно. Энэ нь оноосон нэр маань бидний өдөр тутам харилцаандаа хэрэглэдэг үгээс огт өөр, өөр төвшинд хэрэглэгдэж байгаа, утгазүй- хэлбэр судлалын хувьд ч өөр болсон байдаг. Энэ тухай миний бие “цэцэг” гэдэг үг, “Цэцэг” гэдэг хүний нэр хоёроор жишээ болгон, энэ хоёрын бий болсон хийгээд хэрэглэгдэх төвшин нь өөр, тухайлбал нэг нь үгийн төвшинд, нөгөө нь нэрийн төвшинд байна гэж /5:7-8/ бичиж байсан билээ. Профессор Э.Равдан энэ санаагаа цааш лавшруулан “Аливаад нэр оноох явцад нэрийтгэл нэр нь бодот /denotatum/ утгын буюу тодорхой оногдохуйг заасан шинэ харьцаанд орно. Барс гэж нэгэн зүйл зэрлэг амьтны нэрийтгэл нэр. Тэр нь хүний оноосон нэр болохдоо тодорхой бодгалийг /designatum/ заасан бодот утгатай болно. Оноосон нэр утгын өөр харьцаанд орох учиргүй. Өөрөөр хэлбэл тодорхой оногдохуйг заах нь аливаа оноосон нэрийн түгээмэл үүрэг болой. Тэр нь уг оногдохуйн орших орон зай, цаг хугацаанд зөвхөн үйлчилнэ. Оноосон нэрийн утга зүйн эл онцлог нэрийтгэл нэрд байхгүй. Өөрөөр хэлбэл **оноосон нэр нь тодорхой үүрэг бүтэц бүхий өвөрмөц хэрэглээнд орсон хэлэхүйн нэгж бол, нэрийтгэл нэр нь хэлний нэгж юм.**” хэмээн тодорхойлжээ. /6:9-10/ Энэ бол оноосон нэр, нэрийтгэл нэр хоёрын ялгааг маш оновчтой тодорхойлсон

тодорхойлолт юм. Э.Равдан цааш нь, оноосон нэр, нэрийтгэл нэрийн харьцааны асуудлыг судлаад дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

- Нэрийтгэл хийгээд оноосон нэр нь зарчмын хэд хэдэн ялгаатай. Тэдгээрийн гол нь бүтэц, утгын үүдэл, тоон үзүүлэлт зэрэг болно.
- Оноосон нэр нь хүмүүсийн бүтээл болохын хувьд хэлэхүйн үзэгдэл болой.
- Оноосон нэр нь авиазүй, өгүүлбэрзүй, утгазүй, гарвалзүйн үүднээс иж бүрэн судлахыг шаардах хэлний олон талт өвөрмөц тогтолцоо бүхий судлагдахуун мөн.
- Оноосон нэр нь олон сав ухааны заагт оршдог. Тэдгээр нь оноосон нэрийг өөр өөрийн өвөрмөц зорилгын үүднээс судалдаг бол газар нутгийн нэр зүй / нэр зүй гэвэл зохистой Ж.С./ нь оноосон нэрийг бүхэлд нь судалдаг тул хүрээгээрээ үлэмж өргөн байна.
- Оноосон нэр зүй нь орчин үеийн хэл шинжлэлд хүн, газар нутгийн нэрээр үл хязгаарласан өргөн хүрээтэй салбар болжээ. гэсэн байна. /6:10/

Профессор Э.Равдангийн энэ бүтээл нь цаашаа 1. Монгол газар нутгийн дэвсгэр нэрийн бүрэлдэхүүн, байршил, 2. Монгол газар нутгийн нэрийн хувьслын туршилт судалгаа гэсэн хоёр үндсэн хэсэгтэй 8 бүлгээс бүрдсэн байна. Түүний хөндөн судалсан энэ хоёр асуудал бол монгол газар нутгийн судалгаанд хоёулаа шинэ бөгөөд чухал том асуудал мөн.

Газар нутгийн дэвсгэр нэр хэмээх нэр томъёог анх судлаач Ч.Догсүрэн 1975 онд хэвлүүлсэн “Монголын газар усны нэрийн тогтолцооны зарим асуудлууд” /7:243-251/ өгүүлэлдээ дэвшүүлэн тавьж, дараагийн манай эрдэмтэн, судлаачид дэмжин энэ нэр томъёог одоо хүртэл хэрэглэсээр ирсэн юм. Хэдий тийм боловч монгол газар нутгийн дэсгэр нэр маань ямар тогтолцоотой, ямар үүрэгтэй, ямар утгатай, ямар онцлогтойг нь нээн харуулсан судалгаа байхгүй өнөө хүрч ирсэн билээ. Тэгвэл Проф. Э.Равдан бүтээлийнхээ тэргүүн хэсэгт монгол газар нутгийн дэвсгэр нэрийг бие даасан нэгэн сэдэвт зохиолын хэмжээнд хүртэл дэлгэрүүлэн судалсан нь манай газар нутгийн нэрийн судлалд цоо шинэ судалгаа боллоо.

Тэр бээр ”Газар нутгийн дэвсгэр нэрийг нарийвчлан судлах нь оноосон нэр зүйг амжилтанд хүргэх урьдчилсан чухал нөхцөл болно. Учир нь дэвсгэр нэрийн тодорхой төрөл зүйлээс оноосон нэр олон талаар шалтгаалдаг” /6:11/ гэж үзээд, нийт 240 гаруй дэвсгэр нэрийг монгол хэлний олон тайлбар толь бичиг, бусад сурвалжуудыг ашиглан тодорхойлж, монгол газар нутгийн нэрийн бүрэлдэхүүн, байршлыг дэвсгэр нэрээр нь мөшгөн тогтоосон байна. Дашрамд дурдахад, монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толиудаа хийхдээ дэвсгэр нэрээр нь зүйл хувааж хийсэн нь тун оновчтой шийдэл болсон бөгөөд, нэгэн төрлийн бус тэр олон зуун мянган нэрийг өөрөөр яаж ч толь болгох билээ. Зохиолынхоо хоёрдугаар хэсэгт монгол газар нутгийн нэрийн хувьслыг дэвсгэр нэр, оноосон гишүүний хувьсал хэмээн зааглан үзжээ. Дэвсгэр нэрийг уул, ус, газрын тэгш, хотгор гадаргуу, ургамлын аймагтай холбоотой утгаар нь хуваан хувьслыг нь тогтоож, харин оноосон гишүүнийхээ хувьслыг авиазүй буюу дуудлагын, хэлбэрийн, утгын гэсэн үндсэн гурван хэсэгт хуваан, хэсэг дотор нь нарийвчлан үзэж, хувьслын түгээмэл хэв шинж тус бүрд нь нэрийн хувьслын бичил толийг нотолгоо болгон хавсаргасан нь өөрийн санал, дүгнэлтээ гарцаагүй баримтуудаар баталжээ. Түүнчлэн дээр дурдсан судалгааны нэгэн сэдэвт зохиолдоо газар нутгийн оноосон нэрийн болон дэвсгэр нэрийн давтамжийг аймаг сумаар нь хийж хавсралт болгон хэвлэсэн нь дараагийн судлаач нарт чухал хэрэгтэй лавлах материал болсныг нэмэн хэлэх хэрэгтэй.

Олон жилийн уйгагүй хүч хөдөлмөрөө зориулан, монгол газар нутгийн нэрийн судлалын талаар профессор Э.Равдангийн туурвисан дээрх цуврал 15 боть бүтээл нь орчин үеийн судалгааны арга, арвин баялаг баримт материал, шинэлэг санаа, сонирхолтой дүгнэлтүүдээрээ монгол хэлний нэр зүйн судалгаа, түүний дотор газар нутгийн нэрийн судалгаанд шинэ үзэгдэл болж, улмаар монгол хэлний нэр зүйн судалгааг өнөөгийн олон улсын хэмжээнд гарган ирсэн суурь судалгааны жинтэй бүтээл болсон байна. Үүнийг энгийн үгээр зүйрлэн хэлвэл, “энд монгол газар нутгийн нэрийн судлал буй болон хөгжих юм шүү гээд шав тавьсан буйран дээр гэр орон, мал ахуйгаа авчран гэрээ барьж, хашаа хороогоо төвхнүүлэн, айлын дайтай айл болгосон” хүн нь яах аргагүй профессор Э.Равдан гарцаагүй мөн билээ. Тэр зөвхөн өөрөө судалж, өөрөө туурвиад зогсохгүй, олон арван магистр, докторант, шавь нараа судалгааныхаа ажилд дагуулан сургаж, монгол улсын ирээдүйн нэр зүйч, үгийн сан судлаачдыг бэлтгэж байгаа бас нэгэн гавьяатай хүн гэдгийг эцэст нь цохон тэмдэглэе.

НОМ ЗҮЙ

1. Лувсандэндэв А. (2002) “Монголын үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь”. УБ.,
2. Равдан Э. (2006) Монгол газар нутгийн зүйлчилсэн толь (XX зууны 70-80 оны үе). 5 боть, 8 дэвтэр, CD –ийн хамт. УБ.,
3. Шагдар Ш. (2000) “Монголын газар зүйн нэрийн товч толь бичиг”. нэмж засварласан 3-р хэвлэл, УБ.,
4. Равдан Э. (2006) Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толь (XX зууны 30-40 оны үе). УБ.,
5. Сэржээ Ж. (1992) Монгол хүний нэр. УБ.,
6. Равдан Э. (2008) Монгол орны газар нутгийн нэр зүй. УБ.,
7. Догсүрэн Ч. (1975) “Монголын газар усны нэрийн тогтолцооны зарим асуудалд” Монголын судлал т. II (10). УБ.,

SUMMARY

This review contains the professor E.Ravdan's opinions and conclusions on the following monographs and dictionaries published in recent years.

The Thematic dictionary of Mongolian geographical names (A chief-editor E,Ravdan, UB.2004. 5 volumes, 8 single copies with a searching CD); The thematic dictionary of Mongolian geographical names (Mongolia during the period of Manchu and Autonomous Monarchy) Editorial director E.Ravdan UB. 2004; Thematic dictionary of Mongolian geographical names (During the period of 30's and 40's in the twentieth century) Editorial director E.Ravdan UB.2006; E.Ravdan The research on the forms and semantics of Mongolian geographical names. UB. 2004; E.Ravdan Toponymy of Mongolia (Composition, distribution, and evolution of toponyms) UB.2008; Mongol place-names in the world. Two volumes. Editorial director E.Ravdan UB. 2005, 2006.